

04 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Төрийн үйлчилгээний чиглэлээр: Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийг сумын Засаг даргын А/54 тоот захирамжаар 11 хүний бүрэлдхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлын хамтдаа төлөвшүүлье” уриатай хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян -2022 арга хэмжээний төлөвлөгөөг 14 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Сумын ХАБЭА –н зөвлөл бүх төсөвт байгууллагууд аж ахуйн нэгжүүдээр явж хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзлэг шалгалтыг хийж зөвлөн тусалж ажилласан. 4 сарын 18,19,20 ны өдрүүдэд ISO 9001:2015 стандартын сургалтыг тамгын газрын нийт 32 албан хаагчдад 3 өдөр танхимаар хийж төрийн албан хаагчдын чадамжийн үнэлгээг аймгийн Засаг даргын тамгын газрын хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Оюунтөгс сургалт хийж, чадамжийн үнэлгээг хийсэн. 2022 оны 1-р ээлжийн цэрэг татлага 4 сарын 30 нд явагдаж цэргийн жинхэнэ албанд 11 цэргийн насны залуучууд тэнцэж аймгийн нэгдсэн үзлэгт хамрагдахаар болсон.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд**Нийгмийн халамж:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр 101 иргэнд 28,853,200 төгрөг

Нийгмийн халамжийн тэтгэмж 79 иргэнд 9,061,756 төгрөг

“Цалинтай ээж”-ийн тэтгэмж 273 иргэнд 13,187,156 төгрөг

Жирэмсэн эхийн тэтгэмж 26 иргэнд 1,003,272 төгрөг

Хүүхдийн мөнгө 1736 хүүхдэд 173,600,000 төгрөгийн олголт хийгдсэн байна.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сард 2 удаа хуралдуулж ахмадын асаргаа сунгах 1иргэний хүсэлт, шинээр асаргаанд орох 1 иргэний хүсэлт, ОНОТХҮ-ний төсөлд 1-р багийн иргэн Б.Батхүрэлийн хүсэлтийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.

ХЭБҮ-нд энэ сард 32 өрхийн 153 иргэний 1744,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

2022 хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар FB: Мөнххаан сумын нэгдсэн зар зарлалын групп цахим хуудсанд мэдээллийг нийтэлсэн.

Сумын ХАБЭА-н зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Сарын аяныг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамтдаа төлөвшүүлье” уриан дор зохион байгуулсан. Тус аяны хүрээнд Ажлын байрны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг шалгалтыг хийж зөвлөн тусалсан. ХАБЭА-н сургалтанд сумын зөвлөлөөс 3 хүн хамрагдсан.

“Аж ахуй эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт 7 иргэний төслийг, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих” хөтөлбөрт 2 иргэний төслийг хүлээн аваад байна.

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангийн дансанд 5 иргэн 4.05 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЕБС

Зүүн бүсийн Өсвөр үеийн аварга шалгаруулах ХӨЛБӨМБӨГ-ийн тэмцээн Баруун-Уртсуманд амжилттай зохион байгуулагдлаа. Уг тэмцээнээс Б.Гантогтох багшийн дасгалжуулсан сурагчид амжилттай оролцож "МӨНГӨН" медальхүртлээ.

Төгсөх ангийн сурагчдын нэрэмжит "АХЛАХ" ангийн Эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан ВОЛЕЙБОЛ-ын тэмцээн амжилттай зохион байгуулагдаж дууслаа. Тэмцээнд нийт 6 бүлгийн багш нар болон 36-н эцэг эхчүүд оролцсон.

Хоггүй - Мөнххаан уриалгын дагуу скаутын Нөхөрлөл бүлгэмийн 5-12р ангийн нийт 70 -н сурагч өөрсдийн санаачилгаар Наадмын талбай, Тоглоомын талбай, Ахмадын байр, Гандан, Цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг түүж эрүүл цэвэр орчингбүрдүүллээ.Идэвх санаачлага гарган цэвэрлэж дуусгалаа.

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч, ахмад багш Дамбын Дандарбаатарын нэрэмжит "МӨНХӨД БАДАМЛАХ ХААН НАЙРАГ" яруу найргийн наадам амжилттай болж өндөрлөлөө.

Энэ жилийн наадмын онцлог нь МУСГЗ Д.Нацагдоржийн шагналт зохиолч, яруу найрагч Бямбажавын Хүрэлбаатар , МЗЭ-ийншагналт, "БОЛОР ЦОМ"-ын эзэн яруу найрагч Норовын Гантулга нар шүүгчээр ирж хамтран ажилласан.

Мөн яруу найргийн наадмаар СТА, хөгжмийн багш Л.Энхээгийн хөгжим

" Найргийн тамгатай нутаг" шинэ дуу мэндэлж, жил бүр найргийн наадмын тайзнаа эгшиглэж байхаар боллоо. Найргийн наадамд 6-9-р ангийн 31 сурагч, 10-12-р ангийн 12 сурагч шүлгэн хүлгээ сойж, утга уянгаар хөглөгдөн, урам зоригоор бялхсан сайхан наадам болж өндөрлөв.

"Илүүдэл жингүй эртэч монгол" аянд багш ажилчид нэгдэж өглөө бүр 08:30-09:30 дасгал хөдөлгөөн хийж , ширээний теннис тоглож байна.

ЯХИС-аас хэрэгжүүлж буй "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершипийн боловсрол олгох "төсөл 2021 оноос эхлэн амжилттай хэрэгжиж байна. Тус төслийн хүрээнд 2021 оны хаврынэлсэлтээр ЕБС-ийн 8-12- р ангийн сурагчдаас бүрдсэн 24 суралцагчидтай анги багш Б.Баянбилэгээр удирдуулан хичээллэж 2021.11 сард танхимын сургалтаа дуусган төгсөлтөө хийсэн. Мөн багш Б.Ганганцэцэгээр удирдуулсан НТБ-ын залуучуудын анги 16 суралцагчийн бүрэлдэхүүнтэй 2021.03 сараас хичээллэж эхлээд 2022.01 сардтөгсөлтөө хийсэн.2021 оны намрын элсэлтээр багш Б.Амарзаяа чиглүүлэгч багштай ЕБС-ийн 24 суралцагчтай анги хичээллэж эхлээд 2021.12 сард төгсөлтөө хийсэн.Төслийн дараагийн үе шат тэтгэлэгийн уралдаанд 3 ангиас 7 төсөл бичсэн бөгөөд тэтгэлэгийн 2-р шатанд 4 төсөл тэнцсэн бөгөөд сүүлийн шатны шалгаруулалтаас 2 төсөл дэмжигдэж баталгаажсан. 2022 оны хаврын элсэлтээр ЕБС-ийн 3 ангид 69 сурагч хүсэлтээ илэрхийлэн хичээллэж эхлээд байна.Эдгээр ангиудыг Б.Амарзаяа, Д.Батдулам, Б.Баянбилэг багш нар удирдаж байна.Мөн НТБ-ийн залуучуудын хосолсон сургалттай анги хичээллүүлэхээр сонгогдсон бөгөөд чиглүүлэгч багшаар Б.Шүрэнхүү ажиллахаар бэлтгэгдээд байна.

10.9-р ангийн АУБагштай хамтран сурагчдадаа "Мэргэжилээ хэрхэн сонгох вэ" сургалтыг зохион байгуулж ажиллалаа.Сургалтын зорилго нь 9-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ,тэдний хүсэл сонирхолыг сонсох , зөвлөн туслав. "МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР -III"-ийнхүрээнд 6-12-р ангийн сурагчдын дунд зохион явуулсан" САЙХАН БИЧИГТЭН АНГИ ХАМТ ОЛОН" шалгаруулах уралдаан амжилттай явагдаж, өндөрлөлөө.

Уралдаанд;

- О.Санаатүвшинбагштай ба анги

- Л.Энхээбагштай 7а анги
- Б.Амарзаяабагштай 8б анги
- Д.Батдуламбагштай 9в анги
- Т.Сүглэгмаабагштай 10а анги
- Д.Отгонтуяабагштай 11б анги
- Б.Тунгалагмаабагштай 12а ангиудбүлгийн "САЙХАН БИЧИГТЭН АНГИ"- аар тодорлоо.

Хүүхдийн цэцэрлэг: 1. Арга зүйч энэ сард нийт 17 удаа сургалт үйл ажиллагаанд сууж зөвлөгөө чиглэл өгч ажиллаа.

Судар эгшиглэн -2022 төсөлд оролцогч нар энэ сарын эхний 14 хоногт “Өөрийн сонголт”-ын номоо уншиж, бусдадаа уншсан номоо танилцууллаа.Үүний үр дүнд өөрийгөө илэрхийлэх, чөлөөтэй ярих чадварт суралцаж байна.

“Илүүдэл жингүй – Эртэч монгол” аяны хүрээнд байгууллага дээрээ өглөө бүр 7.20- оос дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. Байгууллагын эмэгтэйчүүдийн зөвлөл, ХАБЭА, Хүүхэд хамгааллын баг сумын цагдаагийн тасагтай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хамтдаа” сургалтыг зохион байгууллаа. Мөнххаан сумын цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч О.Анхбаяр, Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын “Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл” хариуцсан мэргэжилтэн ахмад Б.Ариунтуяа нар сургалтыг зохион байгууллаа. Нийт 10 бүлгийн 57 эцэг эх, 29 багш ажилчид хамрагдлаа. Сумын ХАБЭА зөвлөл байгууллагын ХАБЭА- зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө чиглэл өгч ажилласан. Бүлгүүдийн МЭТ, Дүрслэх урлагийн сургалтын төвүүдийн шинэчлэл хийж, багш бүр бүтээлчээр гар урлал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт хийлээ. Нийт 975 гаруй тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүн хийжээ.

Энэ сард багш нар нийт 20 цахим хичээл, туслах багш нар 11 цахим хөгжөөн баясгах үйл ажиллагаа хийж, байгууллагын дотоод ажлын группт байршуулав.

Байгууллагын угаагч, үйлчлэгч, туслах багш нарт “Ариутгалын бодисыг хэрхэн зөв ашиглах вэ? талаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд туслах багш 10, угаагч 2, үйлчлэгч 2, тогооч 4 нийт 18 хүн хамрагдаж мэдээлэл авч санал бодлоо солилцлоо.

Аймгийн МХГ-аас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр сургалтыг байгууллага дээрээ авсан . Сургалтанд нийт 29 багш, ажилчид хамрагдаж мэдээлэл авч санал бодлоо илэрхийллээ.

ХАБЭА сарын аяны хүрээнд цэцэрлэгийн 10 бүлгийн 124 эцэг эх, асран хамгаалагч нарт “Эрүүл хооллолтын 10 дүрэм” – ийг танилцуулан мэдээлэл өгч гарын авлага тараан “Амин дэм” амталгаат өдөрлөг зохион байгууллаа.

Хүүхэд цэцэрлэгтээ өглөөний цай, бага үдийн унд, өдрийн 1, 2-р хоол, зууш, оройн хөнгөн хооллолт зэрэгт ямар ямар нэр төрлийн, өдөрт авбал зохих илчлэг, амин дэмтэй хоол, унд хэрэглэдгийг эцэг эхчүүдэд танилцуулж амталгаа хийлгэлээ. Өдөрлөгийн үеэр тогооч нар өөрсдийн хийдэг 10 төрлийн зууш, 12 төрлийн шүүс, 10 төрлийн нарийн боов, 7 төрлийн 1,2-р хоол зэргийг хийж танилцуулсан. Ахлах тогооч Х.Энхцэцэг, Э.Уугантуяа нар хүүхдийн хооллолтын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, эцэг эхээс санал авч ярилцлаа. Өдөрлөгт нийт 126 эцэг эх 32 багш, ажилчид нийт 158 хүн оролцлоо.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй -2022” сарын аяны хүрээнд БШУГ-аас батлагдсан “Боловсролын салбарт хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэж буй ажлуудаа олон нийтэд танилцуулах, сурталчлах зорилго бүхий өдөрлөгийг “ Аюулгүй байдал эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриатайгаар М.Дугаржавын нэрэмжит Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг хамтран зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр:

1. Ажлын байрны дасгал хөдөлгөөн

2. Гар урлалын төрлүүд ашиглан хийж сургалт үйл ажиллагаандаа ашигладаг сургалтын хэрэглэгдэхүүний танилцуулга үзэсгэлэн
 3. Ажлын хувцаснаас гадна ,спорт өдөрлөг, чөлөөт үйл ажиллагаа зэрэгт өмсдөг төрлийн хувцасны үзүүлбэр танилцууллаа.
 4. Өөрсдийн тарьж ургуулсан амьд цэцгийн үзэсгэлэн
 5. Хүүхдэд үйлчилдэг хоол үйлдвэрлэл, хоолны илчлэг, шим тэжээлийн талаарх мэдээлэл, танилцуулга үзэсгэлэн, гэсэн төрлүүдээр явагдлаа.
- Өдөрлөгийн үйл ажиллагаанд нийт 158 эцэг эх оролцсон.

Бүлгийн багш нар “Ухаалаг гар утасны хор уршиг” сэдвээр ведео шторк бэлтгэж бүлгүүдийн хүүхдүүдэд мэдээллийг хүргэлээ. Үр дүн: 151 хүүхдэд мэдээ мэдээллийг хүргэж, утасны хор уршгийн талаар өөрсдөөр зураг зуруулж хамтран ярилцлаа. Мөн ухаалаг утасны хор нөлөөллөөс сэргийлж эцэг эх, гэр бүлийнхэнтэйгээ цагийг зөв өнгөрүүлэх талаар хамтран ярилцлаа.

2.Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдлаар.

БШУЯ болон БШУ газраас зохион явуулсан “6 настай хүүхдийн сургуульд бэлтгэсэн байдлыг үнэлэх судалгаа” сургалтад бэлтгэл бүлгийн багш нар хамрагдлаа. Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан 5 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “ХҮМҮҮН БИЧИГ- ХҮН БҮРИЙН БИЧИГ” аяны хүрээнд ЕБС-ын багш Д.Янжмаа байгууллагын багш, туслах багш нарыг монгол бичгээр уншуулж, цэвэр бичих зөвлөгөө өгч ажиллаа. Мөн багш, туслах багшийн 10 бичвэр “Жавхлант шаргын нутаг” уралдааны “Хичээнгүй бичгийн төрөлд” явуулав.

Гамшгаас хамгаалах хуулийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын багш ажилчид тороосон шүүр 16 , цохиур 30-н ширхэгийг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөв.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Дугуйтай Мөнххаанчууд аян”-ы хүрээнд сантехникч болон галч нар Унадаг дугуйн зогсоол хийж, хугацаанд нь байршууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд “Эрүүл, Эрсдэлгүй, Ээлтэй орчин” зурагт хуудас, цахим сурталчилгааны уралдаанд эрхлэгч, бүлгийн багш, хувилбарт сургалтын багш, хөдөлгөөн эрүүл мэндийн багш, туслах багш нар бүгд 100 хувь хамрагдаж видео шторк 12, зурган зөвлөмж 10 ширхгийг хийж бүлгүүдийн болон дотоод ажлын группт байршууллаа.

Соёл: Сүхбаатар - 80 урлагын наадмын бэлтгэл ажлыг ханган нийт 40 гаруй уран сайханчдын бүрэлдхүүнтэйгээр урлагын наадмыг бэлдэж эхлээд байна. Урлагын наадмын зардалд 10,0 сая төгрөгийг Засаг даргын үйл ажилгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гарган дэмжиж ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: 2022 оны 04 сарын 28 -ны байдлаар 67 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 39 насанд хүрэгчид, 28 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 559, урьдчилан сэргийлэх үзлэг 141 байна.

Түргэн тусламжийн дуудлага 26 ирснээс алсын дуудлага – 5 , ойрын дуудлага 24 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Аймгийн мал эмнэлгийн нэгдсэн зөвлөгөөнийг 2022.04.07-оос 08-ны өдрүүдэд зохион байгуулахад сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжийн 9 эмч мэргэжилтэн оролцож, 2022 оны хийх ажлын чиглэлын талаар МЭЕГ-ын дарга, ерөнхий эмч мэдээлэл өгч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд мал эмнэлгийн газартай бүтээгдэхүүн нийлүүлэх гурвалсан гэрээг байгуулж, 3 төрөлт спортын тэмцээнд амжилттай оролцож 3-р байр эзэлсэн.

Гоц халдварт халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд сумын бүх үхрийг хамруулахаар сумын Засаг даргын 2022.04.18-ны өдрийн А/66 тоот захирамжаар 6 ажлын хэсэг гарч ажиллаж байна. Одоогийн байдлаар 370 өрхийн 20750 толгой үхрийг хамруулан вакцинжуулалт 67,2 хувьтай хийгдэж байна. Вакцинжуулалтын зардалд 1071,0 мян төгрөгийн шатахууны зардлыг гарган ажилласан.

Цахим системд малын гарал үүсэл адууны мах 1500 кг, хонины мах 15935 кг, ямааны мах 1640 кг, тус тус бичигдэж баталгаажуулалт хийгдсэн байна.

Дөрөв: Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Сумын засаг даргын 2022 оны 04 сарын 20-ны өдрийн А/68 тоот захирамжийн дагуу “Бүх нийтийн хог цэвэрлэгээ”-г зохион байгуулах ажлыг хийх бэлтгэлээ хангаж албан газар болон аж ахуй нэгжүүдэд мэдэгдэл хүргүүлж бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг 4 сарын 21-24 ны хооронд зохион байгуулсан. Нийт шатахууны зардалд 840250 төгрөгийг байгаль хамгаалах зардлаас зарцуулсан.

Хоёр: Гамшгийн талаар

Аймгийн Засаг даргын 01 албан даалгаврын дагуу төлөвлөгөө гарган батлуулж төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж байна. 03 сарын 20-ноос 06 сарын 10-ны хооронд хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах талаар 5-н багийн 441 иргэнд мэдээллийг өгсөн. Сумын 5-н группт 5-н удаагийн давтамжтайгаар 71 иргэнд цахимаар хүрсэн. Шинээр Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хангах төслөөс 3ш рело, үлээгч аппарат 3ш, малгай 10ш, нүдний шил 10ш, бээлий 10ш, хор 1ш Нийт 3096800 төгрөгний бараа материалыг өгсөн. Сумын засаг даргын 2022 оны 03 сарын 30-ны А/45 албан тоотыг Албан байгууллагын дарга эрхлэгч нарт хүргүүлсэн. Мөн колонкын түгээгч нарт иргэдэд тараах материалыг өгч гарын үсгийн баталгааг авсан.

Бусад ажлын хүрээнд: Тэр бум мод тарих хөдөлгөөний хүрээнд ойн зурвас байгуулах ажилд 36,0 сая төгрөгийг байгаль хамгаалах зардлаас гаргаад бэлтгэл

ажлыг хангаад байна. ХАБЭА –н аяны хүрээнд зохион явагдсан Спортын арга хэмжээнд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 300,0 мян төгрөгийг гарган ажилласан. Мөн ЗДТГ-ын үүдэнд Дугуйн зогсоол байршуулах зардалд 500,0 мян төгрөгийг ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх зардлаас гарган дугуйн зогсоолтой болсон.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.